



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.12, 52.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

Хоёр. Батлагдсан журмыг хэрэгжүүлэн ажиллахыг Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар /Э.Хангай/-т, хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Х.Ганцогт/-д тус тус даалгасугай.

Гурав. Энэ тушаал гарсантай холбогдуулан Сангийн сайдын 2006 оны 55 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Цахим сүлжээнд тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.



682336

Сангийн сайдын 2013 оны 04
дүгээр сарын 19-ний өдрийн 84
дүгээр тушаалтын хавсралт

**ЦАХИМ ХУУДАСТ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ,
ТЕНДЕРИЙН УРИЛГА, ҮР ДҮНГ ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ ЖУРАМ**

Нэг. Зорилго

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авч буй бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтын мэдээллийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудсаар дамжуулан ил тод, шуурхай мэдээлэх, түүнд тавих олон нийтийн хяналтыг сайжруулах, Засгийн газрын худалдан авах ажиллагааны хяналт шинжилгээ, мэдээллийн системийг ашиглахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Үйлчлэх хүрээ

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан захиалагч байгууллага /цаашид “захиалагч” гэх/-үүд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендер шалгаруулалтын урилга, үр дүнг энэхүү журамд заасны дагуу зарлан мэдээлнэ.

Гурав. Нийтлэг заалт

3.1. Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас, худалдан авах ажиллагааны хяналт шинжилгээ, мэдээллийн системийг Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “Сангийн яам” гэх/ хөтөлж, хэвийн үйл ажиллагааг нь хангана.

3.2. Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас /цаашид “цахим хуудас” гэх/ нь www.e-procurement.mn хаягтай байна.

3.3. Засгийн газрын худалдан авах ажиллагааны хяналт шинжилгээ, мэдээллийн систем /цаашид “систем” гэх/ нь www.pmmis.e-procurement.mn хаягтай байна. Захиалагч байгууллагууд энэ журмын 4 дүгээр зүйлд заасны дагуу Сангийн яаманд хандан бүртгүүлж, системд нэвтрэх эрх авна.

3.6. Захиалагч системийг Сангийн яамнаас гаргасан аргачлал зааварчилгааны дагуу ашиглана¹.

3.7. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендер шалгаруулалтын урилга, үр дүнгийн талаарх мэдээллийн үнэн зөв байдлыг захиалагч хариуцна.

¹ Энэхүү зааварчилгаа нь системийн “хэрэглэгч тусламж” хэсэгт байрлана.

Дөрөв. Захиалагчийг бүртгэх

4.1. Захиалагч системд нэвтрэх эрх авахаар бүртгүүлэх хүсэлтээ албан бичгээр ирүүлнэ.

4.2. Албан бичгээр ирүүлэх хүсэлтэд дараах мэдээллийг тусгана.

4.2.1. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

4.2.2. Байгууллагын хаяг, холбоо барих утасны дугаар;

4.2.3. Хариуцах ажилтны нэр, албан тушаал, утас, цахим шуудангийн хаяг.

4.3. Сангийн яам журмын 4.2-т дурдсан мэдээлэл бүрэн эсэхийг нягталж, ажлын 2 хоногт багтаан нэгдсэн бүртгэлд хамруулж, системд нэвтрэх эрх, түлхүүр үг олгоно.

4.4. Захиалагч системд нэвтрэх эрх, түлхүүр үгийн нууцлалыг бүрэн хариуцна.

4.5. Захиалагч нь журмын 4.2-т заасан мэдээлэл өөрчлөгдсөн тухай бүр байгууллагын талаарх мэдээллийг журамд заасны дагуу шинэчлэх бөгөөд систем дэх мэдээллийн шинэлэг, найдвартай байдлыг хангах үүргийг хүлээнэ.

Тав. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг системд оруулах

5.1. Захиалагч өөрийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдсан даруйд систем дэх маягтын дагуу төлөвлөгөөний төслийг оруулан харьялах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

5.2. Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн багцын төлөвлөгөөний төслийг системд оруулж нэгтгэн, Сангийн яаманд хүргүүлнэ.

5.3. Сангийн яам төсвийн ерөнхийлөн захирагчийн ирүүлсэн төлөвлөгөөний төслийг хянан үзээд холбогдох хариуг 2 хоногийн дотор өгнө.

5.4. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төсөл зохих шаардлагыг хангаагүй тохиолдолд системээр дамжуулан захиалагчид мэдэгдэж, холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэхийг шаардана.

5.5. Захиалагч журмын 5.4-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд ажлын 3 хоногийн дотор зохих өөрчлөлтийг хийж, төлөвлөгөөг дахин ирүүлнэ.

5.6. Сангийн яам журмын 5.3.2-д заасны дагуу ирүүлсэн төлөвлөгөөг хянан үзэж зөвшөөрсөн тохиолдолд цахим хуудас руу илгээж нийтэлнэ.

5.7. Тухайн жилийн явцад шинээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шаардлагатай тохиолдолд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.7-д заасны дагуу захиалагчийн ирүүлсэн тодотгосон төлөвлөгөөнд үндэслэн Сангийн яамнаас тухайн байгууллагын төлөвлөгөөг системээс буцаана.

5.8. Буцаагдсан төлөвлөгөөнд захиалагч холбогдох нэмэлт, өөрчлөлтүүд оруулан дахин илгээнээр Сангийн яам журмын 5.3-т заасны дагуу хянан үзэж, шийдвэрлэнэ.

Зургаа. Тендерийн урилга зарлан мэдээлэх

6.1. Захиалагч зөвшөөрөгдсөн төлөвлөгөөнд тусгагдсан тендер шалгаруулалтыг зарлан мэдээлэхээр тогтоосон өдөр тендерийн урилгыг цахим хуудас руу илгээж нийтэлнэ.

6.2. Тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлсэн албан тушаалтны талаарх мэдээлэл системд тухай бүр хадгалагдана.

6.3. Тендерийн урилгыг зарлан мэдээлсэн огноог цахим хуудсанд нийтлэгдсэн өдрөөр тооцно.

6.4. Тендерийн урилга нь цахим хуудсанд нийтэлсэн дарааллаар дугаарлагдана.

6.5. Захиалагчийн өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан тендерийн урилгад цахим сүлжээнд зарлагдсан урилгын огноо, бүртгэлийн дугаарыг дурдах бөгөөд бусад мэдээлэл нь цахим сүлжээнд зарласантай ижил байна.

Долоо. Тендер шалгаруулалтын үр дүнг зарлан мэдээлэх

7.1. Захиалагч гэрээ байгуулсан өдөрт багтаан тендер шалгаруулалтын үр дүнг систем, цахим системд нийтэлнэ.

7.2. Тендер шалгаруулалтын үр дүнгийн талаарх дор дурдсан мэдээллийг цахим сүлжээнд мэдээлнэ. Үүнд:

- 7.2.1. Тендерт оролцогчдын нэр, холбогдох бусад мэдээлэл;
- 7.2.2. Тендерт оролцогч чадварын шаардлага хангасан эсэх, хангаагүй бол үндэслэл;
- 7.2.3. Чадварын шаардлага хангасан тендерт оролцогчийн санхүүгийн санал /Харьцуулах үнэ/;
- 7.2.4. Хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн нэр /Гэрээний үнэ/;
- 7.2.5. Уг тендер шалгаруулалттай холбоотой гомдол гаргасан эсэх, гаргасан бол гомдлын агуулга, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн тухай товч тайлбар;
- 7.2.6. Санхүүжилтийн эх үүсвэр;
- 7.2.7. Бусад шаардлагатай мэдээлэл.

7.3. Төрийн сан нь захиалагчийн зохион байгуулсан тендер шалгаруулалтын үр дүнг цахим хуудаст нийтэлсэн мэдээлэлтэй тулгасны дагуу гэрээний төлбөрийг шилжүүлнэ.

7.4. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнг цахим хуудаст мэдээллээгүй, буруу оруулсан тохиолдолд гэрээний төлбөр шилжүүлэхийг хориглоно.

**Найм. Мэдээллийн бааз үүсгэх, түүнийг сайжруулах,
статистик тайлан мэдээ гаргах**

8.1. Сангийн яам тухайн жилд цахим хуудсаар зарлагдсан тендер шалгаруулалтын тоо, төсөвт өртөг, гэрээ байгуулсан үнэ зэрэг статистик мэдээллийг гаргах, түүнд дүн шинжилгээ хийх, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг бэлтгэх ажлыг зохион байгуулж олон нийтэд цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

8.2. Сангийн яам цахим хуудсаар зарлагдсан тендер шалгаруулалтын тоо, төсөвт өртөг, гэрээ байгуулсан үнэ зэрэг статистик мэдээллийг төсвийн ерөнхийлөн захирагч нарын жилийн тайлантай хамтатган Засгийн газарт дараа оны эхний улиралд багтаан танилцуулна.

Ес. Хариуцлага

9.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйл болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

* * *